

## ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХЭРЭГЖИЛТ АНХААРАХ АСУУДАЛ

### ISSUES OF CONCERNS AND IMPLEMENTATION OF THE CRIMINAL PROCESS OF PAROLE AND PROBATION



ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ  
 ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХЭРЭГЖИЛТ АНХААРАХ АСУУДАЛ

#### Ч.Болд\*

Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал судлалын докторант  
 Bold Ch, Ph.D Candidate in Criminology, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: bok2662626@gmail.com

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн үндэс, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар авч үзсэн ба прокурор, шүүх, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн статистик тоо мэдээлэл, судлаачийн дугаар хорих ангиудын ажилтан, алба хаагч, хоригдлуудаас авсан санал асуулга, түүврийн аргаар авсан фокус ярилцлага хийх замаар авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар бичсэн ба цаашид энэхүү институтийг хөгжүүлэхэд анхаарах асуудлын талаар санал дэвшүүлсэн болно. Хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тавих институт нь хууль эрх зүйн зохицуулалтын хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон холбогдох бусад дүрэм, журмаар зохицуулагдаж байна.

Энэхүү институт нь олон салбарын дунд өөрөөр хэлбэл, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаа, өмгөөллийн зэрэг байгууллагын харилцааны үр дүнд хүний эрхийг хангах чухал процесс, ялын бодлогын нэг чухал өнцөг гэж хэлж болохоор байна. Ялтныг хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн заалтыг зөв хэрэглэх нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хохирол нөхөн төлөх ажиллагаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг төдийгүй ЭХХШТХ-ийн үндсэн зарчмыг хэрэгжих чухал ач холбогдолтой юм.

Энэхүү сэдвийг гүнзгийрүүлэн судлах нь үр дүнгийн хувьд нэг хоригдолд зарцуулж буй нийт зардал хэмнэх, ялын бодлогын хувьд дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад эерэг нөлөө үзүүлж байгаа зэрэг олон талын ач холбогдолтой юм. Бид энэхүү институтийг шүүхийн процесс талаас нь судлан үзэж, хэрэгжүүлэгч байгууллагуудын статистик, мэдээ, тайлан, хорих байгууллагын алба хаагч, хоригдлуудаас авсан санал, асуулга, онол, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг судлан үзэхийг зорилоо.

**Abstract:** This article discusses the current situation, legal basis, and practical difficulties in the process of early release from prison and its monitoring. It is written by analyzing statistical data registered in prosecutors, courts, and police agencies, and information obtained through surveys and focus group interviews conducted by researchers with prison employees, officers, and prisoners. It also makes suggestions on issues to consider in the future development of this institution. The regulation of the law on early release from prison is regulated by the Criminal Code, the Law on Criminal Procedure, the Law on Enforcement of Court Decisions, the Law on Prevention of Crimes and Violations, and other relevant rules and regulations in force in Mongolia.

This institution can be said to be an important process and an important aspect of penal policy among many sectors, that is, as a result of the interaction between institutions such as the court, prosecutor, court enforcement, police, and defense. The correct application of the provisions of the Criminal Code in resolving the issue of early release and supervision of





prisoners plays a major role in protecting citizens and society from criminal attacks, punishing and rehabilitating criminals, preventing criminals and others from committing crimes, and is of great importance for the implementation of the basic principles of the International Criminal Court.

An in-depth study of this topic has many benefits, including saving the total cost of one prisoner and having a positive effect on recidivism in terms of penal policy. We aimed to examine this institution from the perspective of the judicial process, and to examine the statistics, news, and reports of implementing organizations, opinions and questionnaires received from prison officers and prisoners, and the difficulties and situations encountered in theory and practice.

**Түлхүүр үгс:** Хорих ял, хугацаанаас өмнө суллах, эрүүгийн процесс, хяналт тогтоох, ялтан.

**Key words:** Imprisonment, Parole, Criminal process, Probation, Convict.

### Үндэслэл

Түүхийн хувьд дэлхий нийтэд энэхүү институтийг “Parole” гэж (wikipedia, 2024) нэршсэн байна. Франц хэлний “parole” (*Probation*. gov.uk. *Government Digital Service.*, Retrieved 13 June 2013) гэдэг үг нь “амлалт”, “хэлсэндээ хүрэх” гэсэн үгнээс гаралтай энэ нэр томъёо нь Дундад зууны үед амлалт өгсөн хоригдлуудыг суллахтай холбоотой байв. Энэ нь өршөөл үзүүлэх, дахин боломж олгож байсан ба ялыг хөнгөвчлөхөөс эрс ялгаатай бөгөөд тэнсэн суллагдсан хүмүүс ял эдэлж байгаа гэж тооцогдож, “Probation” (Probation and Parole in the United States, 2011" Retrieved 29 August 2017., 2011) буюу тэнссэн, хяналтад байх хугацаандаа шүүгчээс өгсөн үүргийг зөрчсөн тохиолдолд хорих ангид буцаадаг хэлбэрээр хэрэглэж ирсэн байна. Тухайн үед шоронгийн асуудал хүнд байсан тул зарим хөнгөн төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг заавал удаан хугацаагаар хорих биш тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх амлалтыг авч суллаж байсан байна.

Шотландын аялагч, газарзүйч, Хааны Тэнгисийн цэргийн флотын ахмад **Александр Маконочи**. (Samaha, 2006) 1840 онд Австралийн Норфолк арал дахь Британийн хорих колониудын захирагчаар томилогдсон үедээ тэнсэн суллах орчин үеийн санааг анх нэвтрүүлсэн гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Тэрээр зарим нэгэн харгалзагч нарын үгийг сайн сонсдог хоригдлуудыг хорих хугацаа дуусахаас өмнө суллаж нийгэмд буцаж ирэхэд нь бэлтгэх төлөвлөгөө боловсруулсан бөгөөд

үүнд гурван анги орсон. Эхний хоёр нь сайн зан үйл, хөдөлмөр, сурлагын үр дүнд олсон албан тушаал ахихаас бүрддэг.

Системийн гуравдугаар анги нь дүрэм журмыг дагаж мөрдөхийн зэрэгцээ шоронгоос гадуур болзолт эрх чөлөөг хамарсан. Хэрэв зөрчил гаргавал тэднийг шоронд буцаан авч, гурван ангийн шат дамжлагаар бүгдийг шинээр эхлэх болно Тэрээр чөлөө авах тасалбарын тогтолцоогоо шинэчилж, дэлхийн хамгийн анхны өршөөлийн тогтолцоог бий болгосон.

### Үндсэн хэсэг

Манай улсын эрх зүйн системийн хувьд энэхүү институтийг эрт дээр үеэс хэрэглэж, ялын бодлогын хувьд ашиглаж ирсэн байна. Нүүдлийн соёл иргэншилтэй бидний хувьд хоригдож буй этгээдийг төдийлөн удаан хугацаанд байлгах боломж байсангүй. Тиймээс хэрэв анх удаа гэмт үйлдэл гаргаж, дуулгавартай байж, учруулсан хохирол, төлбөрөө нөхөн төлөхөөр болсон бол хааны зарлигаар суллаж байв.

Харин ардын хувьсгал ялж тусгаар Монгол Улсаа байгуулагдаж, Анхны Үнсэн хуулиа баталснаар эрүүгийн болон эрүүгийн процессын хуулиудад энэхүү ажиллагаа нь өөрийн тусгалаа олон улам бүр сайжирч, хэлбэржин бэхэжсээр өнөөдөртэй золгосон байна.

Эдүгээ улс орон хөгжин дэвшиж, мэдээлэл ил тод болохын хэрээр эрх зүйн орчин нь улам бүр боловсронгуй болж, цоорхой, хийдэл, давхардлыг арилгах тал дээр хууль тогтоох байгууллага, эрдэмтэн

судлаачид, иргэдийн оролцоотойгоор хөгжин боловсронгуй болж байна. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2015 онд Эрүүгийн хууль, 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль мөн онд Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулиуд шинэчлэгдэн батлагдан гарснаар зарчмын хувьд нэлээдгүй өөрчлөлт орж эдгээр хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбарын асуудлыг судалгааны талбарт гүнзгийрүүлэн судлан үзэх зайлшгүй нөхцөлийг бий болгож байна.

Төрөөс ялын бодлогыг чангаруулж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шударгаар ял оногдуулахад анхаарах болсон ч мөн эсрэгээрээ гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас чөлөөлөх асуудал чухал байр суурийг эзэлдэг. Ялын бодлогын болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд анхаарч үзэх нэг чухал институт бол хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох ажиллагаа юм. Энэхүү ажиллагаа нь хугацаанаас өмнө суллагдах хүсэлтэй ялтан бүрийг бүх талаар нь судлан үзэж, түүний хохирол нөхөн төлөлт, ялын тодорхой хувийг эдэлсэн эсэх, зан байдал, үзэл санааны төлөвшил, гэмээ ухаарахад нөлөөлсөн нөлөөллийн олон талт хүчин зүйлсийг харгалзан үзэхийг шаарддаг.

Энэхүү институт нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай шууд холбогддог. Судалгааны түвшинд голдуу Эрүүгийн эрх зүй, Шүүхийн шийдвэрийн эрх зүй талаас нь манай улсын хувьд судалсан байна. Иймээс энэхүү институтийг шүүхийн процесс талаас нь судлан үзэж, онол, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг судлан үзэх шаардлага үүсэж байна.

Хамрах хүрээний хувьд шүүгч энэхүү процессыг хэрэгжүүлэх эцсийн

субъектийн хувьд ЭХХШТХ-ийн 37.6 дугаар зүйлийг (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23) удирдлага болгон хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндэслэлийн хүрээнд тухайн ялтны гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зан төлөвөө зөв дадал, амьдралын хэв маягт суралцан өөрчлөх гэсэн хүсэл зорилго, авир, араншингийн онцлог, ёс суртахууны өөрчлөлт зэргээс хамаарах ба тэдний гэм буруугаа хэрхэн ухамсарлаж, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан, хохирлоо хэрхэн барагдуулсан, нас, гэр бүлийн байдлыг сайтар нягтлан үзэж хугацааны өмнө суллах тухай асуудлыг авч үздэг билээ.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн эрх зүйн талаас нь Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд (Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07 ) заасны дагуу хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай асуудлыг хорих байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу хорих байгууллагын оршин байгаа газрын шүүх шийдвэрлэхээр хуульчилж өгсөн байдаг.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй талаас нь хорих ангид түүнийг эрүүгийн хуульд заасан болзол шаардлагыг хангаж байгаа талаас нь авч үздэг байна.

Тэгвэл Эрүүгийн процесс талаас нь шүүгч эцсийн шийдвэрийг гаргаж тухайн хоригдлыг суллах эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны статистикаас гаргасан мэдээллээр шинэчилсэн найруулгаар баталсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойш дараах тоон мэдээлэл гарсан байна.

Үзүүлэлт	Он	2017	2018	2019	2020	2021	2022	2023
ЭХ-ийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШТХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас		1139	1637	2380	2580	6496	1760	2178



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИКААС



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠡᠮᠡᠲᠡ ᠵᠢᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠰᠤ

тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо									
Өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлсөн	Бүгд хүн		6	6	17	26	21	16	25
	Үүнээс	Хорих ял	6	6	17	25	18	13	20
		Зорчих эрхийг хязгаарлах ял	0	0	0	1	3	3	6
Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон хүний тоо			<b>873</b>	<b>1087</b>	<b>1302</b>	<b>1386</b>	<b>1115</b>	<b>834</b>	<b>1125</b>
Үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольсон	Бүгд хүн		0	1	6	0	544	11	76
	Үүнээс	Торгох	0	0	1	0	32	0	0
		Нийтэд тустай ажил хийлгэх	0	0	0	0	5	0	3
		Зорчих эрхийг хязгаарлах ял	0	0	1	0	504	11	13
		Бусад	0	1	4	2	3	0	60

Хүснэгт-1.(2017-2023 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хорих ялаас хугацааны өмнө суллагдсан ялтны тоог харуулсан байдал)

Үүнээс харвал короно вирус талдвар (Ковид-19)-ын цар тахал гарсан үед илүү олон хүнийг Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон байна.

Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар Прокурорын байгууллагаас хорих ял эдэлж байгаа 6006, цагдан хоригдсон 11.896, Зөрчлийн тухай хуульд зааснаар баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн 19.189, албадан саатуулагдсан 6.541, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан 21.480 хүн, хуулийн этгээдийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд анхаарч ажилласан байна. Хорих ял эдэлж байгаа 6006 иргэний 73.7 хувь нь нээлттэй дэглэмд, 24.8 хувь нь хаалттай дэглэмд, 1.5 хувь нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаагийн 254 нь эмэгтэй, 30 нь гадаадын иргэн, 82 нь өсвөр насны хүн байна (УЕПГ-ын тайлан мэдээ,

үндсэн *сайм* 2024, <https://prokuror.mn/post/110934>);

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Прокурорын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгон ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэдэг. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд ялын хугацаагаа дуусгаад гарч ирэх, хугацаанаас өмнө суллагдах гэдэг нь асар ялгаатай ойлголт ба гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилтыг биелүүлэх нэг гол нөхцөл мөн.

Хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тогтоох ажиллагаа нь анхаарал татсан чухал асуудал болж байна.

2017 он батлагдан гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар суллагдсан этгээдийг хяналтдаа байлгах чиг үүргийг Цагдаагийн байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн өгсөн билээ. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2020 онд батлагдсанаар хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тавих харьяаллыг тодорхой зааж өгсөн байна. Гэсэн ч практикт гарч буй нэг хүндрэл бэрхшээл нь хөдөө орон нутаг, суманд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж байдаггүй тул цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах журам, харилцан хамтран ажиллах санамж бичгийг байгуулан хамтран ажиллах ажлын хүрээнд хяналт тогтоож байгаа хэдий ч хяналт тавих процессын хувьд засаж сайжруулах, бүтэц зохион байгуулалт, эдийн засгаас хамаарсан томоохон шийдвэрлэх асуудал үүссэн хэвээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хянан харгалзах чиг үүргийг гүйцэтгэж буй алба хаагчдын ажлын ачаалал их, орон тоо, техник хэрэгсэл дутмаг байгаа зэрэг нь сөргөөр нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох

ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулаагүй, шалгуур шаардлагыг сайтар нягтлан үзээгүйгээс хорих ялаас хугацааны өмнө суллагдсан этгээд нийгэмшиж чадаагүйгээс дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол гарч байна.

Түүнээс гадна хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг тодорхой болгохгүй бол яг ямар хүнийг аюулгүй болсон гэж үзэх нь тодорхойгүй хэвээр үлдсэн. Тиймээс практикт нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хорих ангийн даргын үзэмжээс хамаарах тохиолдол гарч байна.

Тиймээс хууль тогтоомжийн тодорхой бус байдлаас болж дахин гэмт хэрэг үйлдэх хүнийг суллах, цаашлаад төрийн алба хаагчдын хэнийг энэхүү ажиллагаанд хамруулах уу авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулах эрсдэл үүсгэж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байна.

Шүүхээс гаргасан судалгаагаар нийт хянан шийдвэрлэсэн хэрэгт ял шийтгүүлсэн хүнээс Тэнсэгдсэн хүн хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг үйлдэж ял эдлэх болсон хүний тоо харьцангуй бага буюу жил тутам 4-72 хүн байна.

Үзүүлэлт	Хянан шийдвэрлэсэн хэрэг	Ял шийтгүүлсэн	Хянан харгалзах хугацаанд /Тэнсэгдсэн хүн/ гэмт хэрэг үйлдэж ял эдэлсэн тоо	Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан тоо	Нийт эзлэх хувь
2017 он	8839	9019	4	873	0.4
2018 он	12551	12366	44	1087	4.0
2019 он	13427	13011	52	1302	3.9
2020 он	13470	13390	72	1386	5.1
2021 он	12068	11263	17	1115	1.5
2022 он	14202	14394	13	834	1.5
2023 он	13977	14192	12	1125	1.0

Хүснэгт 2 (2017-2023 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэг түүнээс хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүний тоог харуулсан байдал)

Үүнээс харахад нийт хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүмүүсийн 0.4-5.1 хувь нь дахин гэмт хэрэг үйлдсэн гэсэн бага статистик тоо мэдээлэл байна. Тиймээс энэхүү институтийн хэрэгцээ

шаардлага ялын бодлогод чухал үр өгөөжтэй гэж үзэж болохоор байна.

Хорих ангийн байрлаж буй нутаг дэвсгэр хариуцсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч нь энэхүү процессыг хэрэгжүүлэгч субъект нь байдаг.



МОНГОЛЫН УЛСЫН  
ХУУЛЬ ЗӨВЧЛӨӨС  
СЭРГИЙЛЭХ  
ХУУЛЬ



Мэдээжийн хэрэг тухайн хэрэгтний талаар нарийн сайн мэдээлэл байхгүй хорих ангийн арга зүйн зөвлөлийн нарийн шүүлтүүр, прокурорын хяналтаар орсон хүнийг хуулийн шалгуур, шаардлагыг хангасан бол түүний гаргасан хүсэлтийн дагуу эрхийг нь эдлүүлж суллаж байгаа.

Энэхүү институт нь олон салбарын дунд өөрөөр хэлбэл, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаа, өмгөөллийн зэрэг байгууллагын харилцааны үр дүнд хүний эрхийг хангах чухал процесс, ялын бодлогын нэг чухал өнцөг гэж хэлж болохоор байна.

Практикт хоригдол бүрийн хүсэн хүлээдэг нэг боломж бол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах явдал байдаг. Хорих ангид хоригдож байгаа хоригдлуудаас авсан судалгаагаар санал асуулга авсан нийт 300 хоригдлын 282 нь буюу 94 хувь нь хугацаанаас өмнө суллагдах боломжоо авах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн байна. Мэдээж үр өгөөжийн хувьд нийгмийн эерэг үр дагавар, эдийн засгийн хувьд ашигтай, хоригдлуудын хувьд хуульд заасан шаардлагыг хангахын тулд хүсэж тэмүүлэн зан байдлаа засаж, учруулсан хохирлоо нөхөн төлөх зэрэг эерэг үр дүн авчирч байна.

Харин хорих байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгаар “Хорих ялаас хугацааны өмнө суллахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг дурдана уу? гэсэн асуултад “Эрх зүйн орчин сайжруулах”, “хуулийн зарим заалт ойлгомжгүй байдаг”, “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуур нь ойлгомжгүй байна”, “шалгуур шаардлагыг хангаагүй байж нөлөөлөхийг оролддог”, “улс төрийн нөлөө бүхий хүмүүст илүү нээлтэй гэж боддог”<sup>1</sup> гэх мэт хариултыг өгсөн байна.

Иймээс хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг тодорхой болгож, чухам ямар зан байдлыг аюулгүй болсонд тооцох, шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангах талаар хуульд тодорхой зааж

өгөх шаардлага үүсэж байна. Тухайлбал, хорих ангийн дэргэдэх Арга зүйн зөвлөл (ШШГЕГ-ын даргын 2017 оны А/165 дугаар тушаал., 2017) -өөр хэлэлцэх талаар нарийвчлан авч үзээгүй ба анги бүр өөр өөрийн аргаар энэхүү шалгуур үзүүлэлтийг дүгнэж байна.

Харин шүүхийн практикт тухайлбал, тухайн ялтанг заавал биеэр эдэлсэн хоногийг тооцох, шагналын хоногийг тооцохгүй байх тохиолдлууд гарч байна. Энэ нь хуульд заасан журмыг практикт өөрөө хэрэглэж байгаагийн нэг илэрхийлэл юм. Хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэж ялаа эдэлж буй этгээд нь зан байдал, ёс суртахууны хувьд засарч, өөрийн үйлдсэн хэргийн хор уршиг, үр дагаврын талаар ухамсарлан, хорих ангиас даалгасан хөдөлмөр эрхэлж байсан цаашдаа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулах, мөн түүний үйлдсэн гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирлоо нөхөн төлсөн байдал, хорих ял эдэлж байгаа хоригдол нь ямарваа нэгэн ноцтой зөрчил гаргаагүй, засарч хүмүүжих нийгэмших сургалтад хамрагдсан, мөн шүүхээс оногдуулсан 5 жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг, 5 жилээс дээш 12 жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг, 12 жилээс дээш 20 хүртэл жилийн хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн бол хорих анги, албаны даргын тушаалаар байгуулсан “Арга зүйн зөвлөл”-р хэлэлцэж, шаардлага хангасан хүний материалыг прокурорын байгууллагад явуулж, прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэдэг.

Гэтэл шагналын хоногийг оруулан тоолохгүй зарим тохиолдол гарч байгаа нь анхаарууштай асуудал юм. Шүүхийн шийдвэрийг харахад зарим хоригдлууд хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хүсэлтийг тухайн хорих ангидаа гаргаад түүнийг нь авч хэлэлцэхгүй бол хорих

<sup>1</sup>Судлаачийн хоригдлуудаас авсан судалгаа. 2024 он.

ангиа солиод суллагдан гарсан тохиолдол ч байдаг байна.

Мэдээжийн хэрэг нийгмийг түгшээсэн жигшүүрт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хугацаанаас өмнө суллах асуудал төдийлөн яригдахгүй олон улсын туршлага бий. Гэхдээ зарим улс орнууд хүний эрхийг өндөрт тавьдаг тул хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг энэхүү институтэд хамруулдаг байна. АНУ-д хугацаанаас өмнө тэнсэн суллахдаа бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй тавих ба тэднийг хянах утасны программ хүртэл гаргасан байна. Өөрөөр хэлбэл, тухайн хүн өөрийн амьдарч байгаа дүүрэг гэрийн ойролцоо Pedophilia буюу педофел<sup>2</sup> хэдэн хүн, хаана амьдарч байгааг хянах боломжтой гэсэн үг юм.

Манай улсын хувьд Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй хэмээн хязгаарлалтыг нарийвчлан тогтоосон байдаг.

#### **Хяналт тогтоох ажиллагаа:**

ЭХХШТХ-ын 37.6 дугаар зүйлд заасны дагуу шүүгч нь хорих ялаас хугацаанаас өмнө суллахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоох шийдвэрийг гаргадаг. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шүүгчийн шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлдэг.

Харин энэхүү шийдвэр практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар авч үзвэл нэлээдгүй хүндрэл бэрхшээл гарч байна. Тухайлбал, хугацаанаас өмнө суллагдсан хүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналт тавин ажиллаж байна. Харин Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41 дүгээр зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн

найруулга/ , 2019) / Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох/-ийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан **хүнд гэмт хэрэг** үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас захиргааны хяналт тогтоодог.

Цагдаагийн байгууллагад 2024 оны хагас жилийн байдлаар (ЦЕГ-ын хагас жилийн тайлан, 2024) хяналтад байгаа шүүхээс суллагдсан 306, хорих ялаас хугацааны өмнө суллагдсан 226, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 10, жирэмсэн, гурав хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 42, хорих ял эдлээд суллагдсан 117, нийт 704 хүнд захиргааны хяналт тогтоосон байна.

Үүнээс хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 120, бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 31 хүн цагдаагийн байгууллагын захиргааны хяналтад байна. Бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэрэгт ял эдлэн суллагдаж, захиргааны хяналтад байгаа 31 хүний 21 нь орон нутагт, 10 нь нийслэлд байгаагаас, хугацаа дуусаж суллагдсан 5, хугацаанаас өмнө суллагдсан 26, хохирогчийн оршин суугаа газрын дүүрэг, хороо, багт хяналтад авагдсан 4 тохиолдол байна.

Хөдөө орон нутагт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч сумдад, цаашлаад хөдөө багт ажиллахад орон тоо, хөрөнгө, санхүүгийн асуудал үүсдэг байна. Үүнээс гадна энэхүү ажиллагаанд прокурорын байгууллагын үүрэг оролцоо чухал билээ.

Шүүхээс хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүнд хяналтын хугацаанд

<sup>2</sup>(pedophilia) гэдэг нь Олон Улсад арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон хүнийг ойлгодог.





үүрэг хүлээлгэж болох ба үүрэг хүлээлгэсэн тохиолдолд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын дүгнэлтээр шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр тогтоодог.

#### **Ач холбогдол:**

Ач холбогдлын хувьд энэхүү ажиллагаа нь ялтанд төрөөс олгож буй боломж, итгэл үзүүлж буй нэг хэлбэр төдийгүй, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн ялын нэг бодлого юм.

Улсын төсвөөс нэг өдөрт ялтанд зарцуулж буй хөрөнгийг хэмнэх эерэг арга хэрэгсэл төдийгүй эдийн засгийн хувьд үр өгөөжтэй институт гэж үзэж болохоор байна.

Үүнээс гадна мэдээж хохирол нөхөн төлөх тохиолдолд болзол шаардлагыг хангаж байгаа тул гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлтэд онцгой ач холбогдолтой төдийгүй ЭХХШТХ-ийн үндсэн зарчим хэрэгжих чухал нөлөөтэй гэж дүгнэж болохоор байна.

#### **Дүгнэлт**

1. Энэхүү институц нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, өмгөөллийн зэрэг салбар хоорондын үйл ажиллагаатай шууд холбогддог билээ. Ялтныг хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн заалтыг зөв хэрэглэх нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилтыг биелүүлэх, эдийн засгийн үр өгөөжтэй нэг гол нөхцөл юм. Мөн хохирол нөхөн төлөх ажиллагаанд томоохон хөшүүрэг болж, онцгой үүрэгтэй төдийгүй ЭХХШТХ-ийн үндсэн зарчим хэрэгжих чухал нөлөөтэй.

2. Хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагаа нь ялтанд төрөөс олгож буй боломж, итгэл үзүүлж буй нэг хэлбэр төдийгүй, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн ялын нэг бодлого тул энэхүү институтын эрх зүйн орчныг сайжруулах тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэхүү

институтийн ач холбогдлыг нэмэгдүүлэн шүүхээс хуульд заасан үндэслэл, журмын дагуу хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

3. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих чиг үүргийг хуулийн дагуу явуулж буй шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий ажилтан, алба хаагчдын ажлын ачаалал их байх, машин техник хэрэгсэл орон нутагт дутагдалтай байгаа зэрэг нь энэхүү ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа тул цаашид төрөөс анхаарах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

4. Эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай ба хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг эрүүгийн хуульд тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

#### **Санал**

1. Хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүмүүсийн 7 жилийн судалгаагаар дахин гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 0.4-5.1 хувь нь дахин гэмт хэрэг үйлдсэн байх тул шалгуур шаардлага хангасан хүмүүсийг энэхүү ажиллагаанд түлхүү хамруулж, шүүхийн практикийг нэмэгдүүлэх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хянан харгалзах чиг үүргийг гүйцэтгэж буй алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, орон тоог нэмэх, машин техник хэрэгслээр хангах.

3. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг тодорхой болгох.

4. Хяналт тавих процессыг практикт зөв зохион байгуулалтад оруулж, эрх зүйн үндсийг илүү тодорхой болгох.

#### **Ашигласан материал**

Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2017).

*Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (Шинэчилсэн найруулга). №23.*

Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2016).

*Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). №07.*



- Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2019). *Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (Шинэчилсэн найруулга)*. №42.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. (2017). *ШШГЕГ-ын даргын 2017 оны А/165 дугаар тушаал*.
- Улсын Ерөнхий Прокурорын газар. (n.d.). *УЕПГ-ын үндсэн сайт*. Retrieved from <https://prokuror.mn/post/110934>
- Цагдаагийн ерөнхий газар. (2024). *ЦЕГ-ын хагас жилийн тайлан*.
- Government Digital Service. (2013, June 13). *Probation*. Retrieved from <https://www.gov.uk>
- Samaha, J. (2006). *Criminal Justice*. Belmont, CA: Thomson/Wadsworth. ISBN 9780534645571.
- Petersilia, J. (2003). *When Prisoners Come Home: Parole and Prisoner Reentry*. Oxford: Oxford University Press.
- U.S. Department of Justice. (2014, April). *Probation and Parole in the United States, 2011* (PDF). Bulletin. Retrieved from <https://www.ojp.gov>

